



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/136/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Сайншанд сум

2020 он

Тэргүүлэх аудитор: .....Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

Аудитын менежер: .....Э.Энхцэцэг

Утас: 70523020

Цахим хаяг: [enktsetseg.e@audit.gov.mn](mailto:enktsetseg.e@audit.gov.mn)

Ахлах аудитор: .....Ц.Лүндэгмаа

Утас: .....

Цахим хаяг: [lundegmaa.ts@audit.gov.mn](mailto:lundegmaa.ts@audit.gov.mn)

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.12	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.13.	Шилэн дансны мэдээлэл	10
2.14	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	14

## 1 Аудитын гэрчилгээ


 <b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сафр: dornogovi@audit.gov.mn	<b>АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Н.ХОНГОРЗУЛ ТАНАА</b>
2020. 02. 28 № 1-6/147 танай _____ -ны № _____ -т	
<b>Аудитын гэрчилгээ</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
<b>Зөрчилгүй санал дүгнэлт</b>	
<p>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
<b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	

**Үүрэг, хариуцлага**

Аймгийн Төлөөлөгчдийн хурал Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Нарийн бичгийн дарга Н. Хонгорзул танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 22-ноос 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 28-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Лүндэгмаа, О.Нарангарав хариуцаж хэрэгжүүлэв.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 35 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Эрхэм зорилго:

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Монгол Улсын хуулиудад заагдсан эрх, үүргийн биелэлтийг ханган нутгийн өөрөө удирдах ёсны чадавхийг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн байдалд төлөөлөгчдөөр дамжуулан иргэдийн хяналт, оролцоог дээшлүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгааг бий болгох бодлого шийдвэрийг боловсруулан хэрэгжүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ. Үүнд:

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны үйл ажиллагааг аймгийн хөгжлийн зорилтуудыг сайтар хэрэгжүүлэхэд чиглүүлэн хүртээмжтэй зохион байгуулан, хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангуулна.
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны үйл ажиллагааг шуурхай хангаж, ИТХ-д хуулиар олгогдсон бүрэн эрх, үүргийн хүрээнд орон нутаг болон иргэдийн ашиг сонирхолд нийцүүлсэн бодлого боловсруулж оновчтой шийдвэр гарган ажиллана.
- Төлөөлөгч, хурлын хороодыг идэвхжүүлэн Хуралд хуулиар олгогдсон хяналт шалгалтын ажлын үр дүнг дээшлүүлэн хуулийн хэрэгжилт, аймгийн эдийн засгийн чадавхыг сайжруулахад нөлөөлж ажиллана.
- Хурлын төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ төлөөлөгч-иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах замаар иргэдийн идэвх оролцоог дээшлүүлнэ.
- ИТХ-ын үйл ажиллагаа, гарсан шийдвэрийг олон нийтэд шуурхай хүргэж, тэмдэглэлт өдөр, хууль тогтоомжийг сурталчлах нөлөөллийн ажлуудыг хийн Хурал, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулна.
- Хурлын ажлын албаны шуурхай байдлыг ханган нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэхэд шаардагдах ажлыг зохион байгуулна.

### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “асолус” програм хангамж ашигладаг байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд (Дунд) гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт (Үр нөлөөтэй) гэж үзлээ.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 934,587.7 мянган төгрөгөөс тооцон 9,345.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг түвшинг 9,462.9 мянган төгрөгөөр тооцсон болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,883.8 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00	00	
Авлага	119.6	1,771.7	1,652.1
Урьдчилгаа	513.8	00	-513.8
Бараа материал	12,444.1	37,348.5	24,904.4
Үндсэн хөрөнгө	325,895.6	336,727.4	10,831.8
Хуримтлагдсан элэгдэл	-122,104.3	-161,862.6	-39,758.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>216,868.8</b>	<b>213,985.0</b>	<b>-2,883.8</b>
Өр төлбөр	314.6	323.2	8.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	216,554.2	213,661.8	-2,892.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>216,868.8</b>	<b>213,985.0</b>	<b>-2,883.8</b>

Авлага дансны үлдэгдэл 1,652.1 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны авлагын 119.6 мянган төгрөгийг барагдуулж, тайлант хугацаанд Таван богд ХХК-д сэлбэгийн үнэ 2100.0 мянган төгрөг шилжүүлж 1.7 сая төгрөгийн сэлбэг бүрэн аваагүйгээс үүссэн авлагатай холбоотой байна.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдлийг Нийгмийн даатгалын хэлтэст 74.0 мянган төгрөг илүү шилжүүлснийг, Наран аялгуу ХХК-д гэрээний төлбөр 300.0 мянган төгрөг илүү төлсөн байсныг тус тус суутган тооцсон, НИК ХХК-д 139.8 мянган төгрөг илүү шилжүүлснийг тооцоо нийлж толон орлогодож авснаар барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 24,904.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бичиг хэргийн материал 1,906.3 мянган төгрөгөөр, аж ахуйн материалын үлдэгдэл 20,631.7 мянган төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 349.0 мянган төгрөгөөр түлш шатахуун 2,017.4 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,831.8 мянган төгрөгөөр өссөн нь нийт хөрөнгө 20,209.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 9,378.1 мянган төгрөгөөр буурсан байна. Үүнд: Тоног төхөөрөмж дансанд 16,389.9 мянган төгрөгийн 1 компьютер, 2 принтер, 1 ус буцалгагч, зургийн аппарат, кондейшн зэрэг хөрөнгө, тавилга, эд хогшил дансанд 3600.0 мянган төгрөгийн архивын тавиур тус тус нэмэгдсэн байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 74 дүгээр тогтоолын 1-р хавсралтаар тоног төхөөрөмж данснаас 7,201.0 мянган төгрөгийн, тавилга эд хогшил данснаас 10.2 мянган төгрөгийн хөрөнгө акталж, мөн тогтоолын 2-р хавсралтаар тоног төхөөрөмж данснаас 2,167.0 мянган төгрөгийн хөрөнгийг Өргөн сумын ИТХ-д шилжүүлжээ.

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл данс 39,758.3 мянган төгрөгөөр өссөн зөрүү нь 49,136.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, данснаас хасагдсан хөрөнгийн 9,378.2 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,892.4 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүн данс 2,892.4 мянган төгрөгөөр илэрхийлэгдсэнээс шалтгаалжээ.

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 921,356.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар төсөв батлагдсан бөгөөд нийт зардлын 921,356.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Төсвийн гүйцэтгэлийн тайланд илэрхийлэгдсэн 1,420.9 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого нь гэрээний дагуу хэмнэгдсэн орлого байна.

Урсгал зардалд гүйцэтгэлээр 911,540.7 мянган төгрөг зарцуулсан нь батлагдсан төсвийг 11,237.0 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэгдсэн 11,237.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд Лондон хотын амьтан судлалын нийгэмлэгийн төслөөр Олон нийтийн цагдаагийн урамшуулалд 9,450.0 мянган төгрөг, “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслөөс төвийн (ДГА-2020/136/СТА-ТШЗ)

бүсийн аймгуудын уулзалт, зөвлөгөөний санхүүжилт 9,571.5 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-аас шилдэг аймгийн шагналд 1.0 сая төгрөг тус тус орж ирснийг тухайн арга хэмжээнд 100 хувь зарцуулжээ.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 7 эрсдэлд горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 134,927.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 127,284.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,516.9 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага бичиж, 126.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 7,516.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэнд 3 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төсвөөс Прокурорын газарт 3,200.8 мянган төгрөгийн проектор, Улсын бүртгэлийн хэлтэст 1,816.1 мянган төгрөгийн камер, төлөөлөгчдийн тойрогт ажиллах зардлын төсвөөс Хөвсгөл сумын Цэцэрлэг, Соёлын төвд тус бүр нь 1250.0 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг notebook авч өгсөн байна. Хөрөнгүүдийг тухайн байгууллагуудад биетээр хүлээлгэн өгсөн боловч байгууллагууд хөрөнгийг дансанд бүртгээгүй, мөн ИТХ-ын нягтлан бодох бүртгэлд нийт 7,516.9 мянган төгрөгийн хөрөнгийг балансын дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Биетээр байхгүй байгаа, бүртгэлд тусгагдсан 7516.9 мянган төгрөгийн хөрөнгүүдийг данснаас хасаж Прокурорын газарт 3,200.0 мянган төгрөгийн проектор, Улсын бүртгэлийн хэлтэст 1,816.1 мянган төгрөгийн камер, Хөвсгөл сумын Цэцэрлэг, Соёлын төвд тус бүр 1250.0 мянган төгрөгийн нэг ширхэг notebook-ийг зарлагдаж дээрх байгууллагуудын дансанд тусгуулах албан шаардлага өглөө.

2. МУ-ын төсвийн тухай хууль болон Сангийн сайдын тушаалаар баталсан зардлын зүйл анги, арга хэмжээний жагсаалтад аймгийн “ИТХ-д суудалтай намын дэмжлэг” гэсэн зардлын нэр төрөл тусгагдаагүй байхад ИТХ-д суудалтай намд олгох дэмжлэг гэсэн зардлын төрөлд 153.0 сая төгрөгийн төсөв баталж 145.0 сая төгрөг зарцуулсан байна. Тухайлбал: Монгол ардын намын байрны гэрэл цахилгаан, дулаан, намын ажиллагсдын цалин, нийгмийн даатгалын шимтгэл, намын үүрийн дарга нарын гар утасны нэгж, шагналт цалин, сумдын намын байрны засвар зэрэг зардлыг санхүүжүүлсэн байна.

Энэ нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 22 дугаар зүйлийн 22.5-д “Төсвийн ангиллын зүйлд санаатайгаар буруу мэдээлэл оруулж төсвийн орлого, зарлагын хэмжээг өөрчлөхийг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрхзүйн үндэслэлгүйгээр аймгийн ИТХ-д суудалтай намд дэмжлэг гаргаж байгаа зөрчлийг зогсоох, төсөв батлахгүй байх албан шаардлага өглөө.

3.МУ-ын төсвийн тухай хууль болон Сангийн сайдын тушаалаар баталсан зардлын зүйл анги, арга хэмжээний жагсаалтад “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн тойрогт ажиллах зардал” гэсэн зардлын нэр төрөл тусгагдаагүй байхад 155.0 сая төгрөгийн төсөв баталж 154.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Тухайлбал: Төлөөлөгчийн тойрогтоо хийх ажлын төсөв, жагсаалтаас харахад ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх боломжтой хүүхдийн тоглоомын талбай байгуулах, сүүдрэвч, жишиг хашаа барих, байр тохижуулах, төсөвт байгууллагуудад хөрөнгийн дэмжлэг үзүүлэх зэрэг ажлууд байгаа ба ажлын гүйцэтгэлээр зарим төлөөлөгч хийгдэх ажлын төсөв, жагсаалтад байхгүй үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулсан байна.

Энэ нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 22 дугаар зүйлийн 22.5-д “Төсвийн ангиллын зүйлд санаатайгаар буруу мэдээлэл оруулж төсвийн орлого, зарлагын хэмжээг өөрчлөхийг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрхзүйн үндэслэлгүйгээр Хурлын Төлөөлөгчийн тойрогт ажиллах зардал гаргаж байгаа зөрчлийг зогсоох, төсөв батлахгүй байх албан шаардлага өглөө.

## **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй байна.

## **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 124 мэдээллийг хугацаанд нь, 24 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

**2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**  
Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.2 сая төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлж хариуг 2019 оны 03 сарын 22-ны 108 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт: Цалингийн зардалд нийт 120.9 сая төгрөг зарцуулсан бөгөөд ажиллагсдаас суутгасан суутгал, НДШ, ХХОАТ-т төлөх өглөгийг дутуу шилжүүлэх, авлага, өглөгийн дүнг зөрүүтэй тооцсон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3 “Бүх өр төлбөр” 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчиж байна.

3.1.2. Эрсдэл: Цалингаас суутгасан татварыг илүү, дутуу шилжүүлэх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтуудыг хэрэгжүүлж дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог тухай бүр хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулж байх

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2.1. Илрүүлэлт: Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”-д байхгүй нэр төрөл болох Хурлын даргын нөөц хөрөнгийн зардалд 2018 оны 12 дугаар сард 156.0 сая төгрөгийн төсөв баталсан бөгөөд 2019 оны 12 дугаар сард 192.0 сая төгрөг буюу 36.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсвийг тодотгон баталсан байна. АИТХ-ын 2018 оны 07/23 дугаар тогтоолоор АИТХ-ын даргын нөөц

хөрөнгийг зарцуулах журам гаргасан бөгөөд журмыг үндэслэн хурлын даргын нөөц хөрөнгөөс биеийн тамирын уралдаан тэмцээнд оролцогчдод дэмжлэг, зочид төлөөлөгчдийг хүлээн авах зардал, уулзалт, зөвлөгөөний буудал, хоолны зардал, шатахуун, материалын үнэ, байгууллагуудад хөрөнгийн дэмжлэг, шагнал урамшуулал, зэрэгт нийт 191,890.2 мянган төгрөгийн зардал гаргаж төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 22 дугаар зүйлийн 22.5-д “Төсвийн ангиллын зүйлд санаатайгаар буруу мэдээлэл оруулж төсвийн орлого, зарлагын хэмжээг өөрчлөхийг хориглоно” гэсэн заалт, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 6.2-т төсвийн болон холбогдох хууль тогтоомжоор зохицуулахаар заасан заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

3.2.3 Өгсөн зөвлөмж: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>13,077,439.82</b>	<b>39,120,247.73</b>
33	АВЛАГА	119,596.00	1,771,752.00
335	Бусад авлага	119,596.00	1,771,752.00
3351	Байгууллагаас авах авлага	119,596.00	1,771,752.00
34	УРЬДЧИЛГАА	513,757.99	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	513,757.99	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	12,444,085.83	37,348,495.73
354	Хангамжийн материал	12,444,085.83	37,348,495.73
35410	Бичиг хэргийн материал	1,072,200.00	2,978,500.00
35420	Аж ахуйн материал	10,544,682.19	31,176,382.19
35430	Сэлбэг хэрэгсэл	820,500.00	1,169,500.00
35440	Түлш, шатах тослох материал	6,703.11	2,024,113.01
35460	Хүнсний материал	00.53	00.53
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>203,791,375.34</b>	<b>174,864,794.60</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	203,791,375.34	174,864,794.60
392	Биет хөрөнгө	195,324,635.60	169,080,937.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	237,000,000.00	237,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-66,316,666.63	-108,116,666.59
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,780,750.00	39,802,650.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-27,793,923.22	-20,021,353.42
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,553,353.44	39,143,198.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,898,877.99	-18,726,891.39
393	Биет бус хөрөнгө	8,466,739.74	5,783,857.54
39301	Програм хангамж	00.00	220,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,561,528.79	20,561,528.79
39304	Хуримтлагдсан элэгдэл	-12,094,789.05	-14,997,671.25
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>216,868,815.16</b>	<b>213,985,042.33</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>314,570.99</b>	<b>323,197.50</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	314,570.99	323,197.50
413	Өглөг	314,570.99	323,197.50
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	314,570.99	323,197.50
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>216,554,244.17</b>	<b>213,661,844.83</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	216,554,244.17	213,661,844.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	68,719,077.67	68,719,077.67
51102	- хувийн	68,719,077.67	68,719,077.67
512	Хуримтлагдсан үр дүн	147,099,424.55	144,207,025.21
51210	Өмнөх үеийн үр дүн	147,099,424.55	147,099,424.55
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-2,892,399.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	735,741.95	735,741.95
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>216,868,815.16</b>	<b>213,985,042.33</b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>843,749,900.00</b>	<b>943,349,080.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>209,000,000.00</b>	<b>1,970,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>209,000,000.00</b>	<b>1,970,800.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	209,000,000.00	1,970,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,420,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	209,000,000.00	549,900.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>634,749,900.00</b>	<b>941,378,280.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>580,278,200.00</b>	<b>921,356,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	580,278,200.00	921,356,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>54,471,700.00</b>	<b>20,021,480.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,471,700.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	19,021,480.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>688,977,967.39</b>	<b>946,288,979.34</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>688,977,967.39</b>	<b>946,288,979.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>675,448,052.39</b>	<b>932,051,965.44</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>99,899,563.00</b>	<b>120,900,918.00</b>
210101	Үндсэн цалин	95,871,563.00	116,958,918.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,028,000.00	3,942,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>11,776,712.00</b>	<b>14,783,442.60</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,213,612.00	10,554,150.60
210202	Тэтгэмжийн даатгал	929,388.00	1,039,076.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	790,080.00	863,910.00
210204	Ажилгүйдлийн даатгал	168,261.00	211,709.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,675,371.00	2,114,597.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,563,107.90</b>	<b>35,282,786.10</b>
210401	Бичиг хэрэг	1,277,556.00	3,198,682.00
210402	Тээвэр, шатахуун	9,460,719.90	22,634,644.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,080,800.00	7,372,231.00
210404	Ном, хэвлэл	00.00	312,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариунгал	144,000.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,032.00	1,621,229.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,714,870.00</b>	<b>11,844,633.00</b>
210604	Урсгал засвар	3,714,870.00	11,844,633.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>5,557,510.00</b>	<b>9,868,400.00</b>
210701	Гадаад албан томиллолт	130,400.00	791,400.00
210702	Дотоод албан томиллолт	5,427,110.00	9,077,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>375,046,998.99</b>	<b>489,888,975.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	372,282,085.99	487,179,439.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,381,175.00	1,998,560.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,738.00	159,176.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	27,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	200,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>164,889,290.50</b>	<b>249,482,810.74</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	106,620,042.47	168,691,253.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,126,695.00	31,655,077.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,142,553.03	49,136,480.74
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,529,915.00</b>	<b>14,237,013.90</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>3,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	3,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>13,529,915.00</b>	<b>11,237,013.90</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,529,915.00	11,237,013.90
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>154,771,932.61</b>	<b>-2,939,899.34</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>47,500.00</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00.00	47,500.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>47,500.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>154,771,932.61</b>	<b>-2,892,399.34</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>634,749,900.00</b>	<b>942,799,180.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>1,420,900.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>00.00</b>	<b>1,420,900.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,420,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,420,900.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>634,749,900.00</b>	<b>941,378,280.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>580,278,200.00</b>	<b>921,356,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	580,278,200.00	921,356,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>54,471,700.00</b>	<b>20,021,480.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,471,700.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	19,021,480.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>632,956,900.00</b>	<b>923,139,180.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>632,956,900.00</b>	<b>923,139,180.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>619,426,985.00</b>	<b>908,902,166.10</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>99,769,217.00</b>	<b>120,824,995.10</b>
210101	Үндсэн цалин	95,494,298.00	116,168,356.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,274,919.00	4,656,639.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>12,040,725.00</b>	<b>14,793,596.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,424,491.00	10,868,396.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,106,366.00	981,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	802,947.00	785,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	155,833.00	196,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,551,088.00	1,962,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,897,348.00</b>	<b>38,989,142.00</b>
210401	Бичиг хэрэг	1,535,556.00	5,557,700.00
210402	Тээвэр, шатахуун	14,419,200.00	20,266,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,999,600.00	7,038,613.00
210404	Ном, хэвлэл	00.00	312,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	798,992.00	5,670,329.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,686,069.00</b>	<b>13,828,885.00</b>
210604	Урсгал засвар	3,686,069.00	13,828,885.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,557,510.00</b>	<b>9,950,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,557,510.00	9,950,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>372,231,494.00</b>	<b>497,575,548.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	369,847,756.00	494,866,012.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,000,000.00	1,998,560.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	173,738.00	159,176.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	27,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	200,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>106,244,622.00</b>	<b>212,939,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	98,519,456.00	177,490,206.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,725,166.00	35,449,394.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,529,915.00</b>	<b>14,237,013.90</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>3,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	3,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>13,529,915.00</b>	<b>11,237,013.90</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,529,915.00	11,237,013.90
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1,793,000.00</b>	<b>19,660,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,793,000.00</b>	<b>19,660,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,793,000.00</b>	<b>19,660,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,793,000.00</b>	<b>19,660,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,793,000.00	19,660,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-1,793,000.00</b>	<b>-19,660,000.00</b>

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	68,719,077.67	735,741.95	-7,672,508.06	00.00	61,782,311.56
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>68,719,077.67</b>	<b>735,741.95</b>	<b>-7,672,508.06</b>	<b>00.00</b>	<b>61,782,311.56</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	154,771,932.61	00.00	154,771,932.61
C08	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>68,719,077.67</b>	<b>735,741.95</b>	<b>147,099,424.55</b>	<b>00.00</b>	<b>216,554,244.17</b>
D01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>68,719,077.67</b>	<b>735,741.95</b>	<b>147,099,424.55</b>	<b>00.00</b>	<b>216,554,244.17</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>68,719,077.67</b>	<b>735,741.95</b>	<b>147,099,424.55</b>	<b>00.00</b>	<b>216,554,244.17</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,892,399.34	00.00	-2,892,399.34
D09	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>68,719,077.67</b>	<b>735,741.95</b>	<b>144,207,025.21</b>	<b>00.00</b>	<b>213,661,844.83</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	921,356,800.00	922,777,700.00	-1,420,900.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	921,356,800.00	922,777,700.00	-1,420,900.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	919,356,800.00	909,540,686.10	9,816,113.90
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	122,074,900.00	120,824,995.10	1,249,904.90
210101	Үндсэн цалин	116,554,900.00	116,168,356.10	386,543.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,520,000.00	4,656,639.00	863,361.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14,921,200.00	14,793,596.00	127,604.00
210201	Тэтгэврийн даатгал	10,996,100.00	10,868,396.00	127,704.00
210202	Тэтгэмжийн даатгал	981,300.00	981,300.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	785,200.00	785,000.00	200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	196,000.00	196,300.00	-300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,962,600.00	1,962,600.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	39,326,300.00	38,989,142.00	337,158.00
210401	Бичиг хэрэг	5,584,000.00	5,557,700.00	26,300.00
210402	Тээвэр, шатахуун	20,266,500.00	20,266,500.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	7,236,000.00	7,038,613.00	197,387.00
210404	Ном, хэвлэл	312,800.00	312,000.00	800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	144,000.00	36,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,747,000.00	5,670,329.00	76,671.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	18,903,000.00	18,868,885.00	34,115.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,040,000.00	5,040,000.00	0.00
210604	Урсгал засвар	13,863,000.00	13,828,885.00	34,115.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	9,967,400.00	9,950,400.00	17,000.00
210702	Дотоод албан томиллолт	9,967,400.00	9,950,400.00	17,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	486,664,000.00	478,774,068.00	7,889,932.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	483,680,000.00	475,844,532.00	7,835,468.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,000,000.00	1,998,560.00	1,440.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	159,176.00	40,824.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	27,800.00	12,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	420,000.00	420,000.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	227,500,000.00	227,339,600.00	160,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	192,000,000.00	191,890,206.00	109,794.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	35,500,000.00	35,449,394.00	50,606.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,000,000.00	2,000,000.00	0.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,000,000.00	2,000,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	0.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	921,356,800.00	922,777,700.00	-1,420,900.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	921,356,800.00	921,356,800.00	0.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	921,356,800.00	921,356,800.00	0.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	09.00	09.00	0.00
620001	Удирдах ажилтан	02.00	02.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	05.00	05.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00	0.00

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>20,021,480.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>20,021,480.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		19,021,480.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		19,021,480.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		19,021,480.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	1000000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	20021480.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		20,021,480.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		19,021,480.00